

ШИНЭЧЛЭН БОЛОРСРУУЛАГДСАН ИНД-66-Р ДҮРМИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p align="center">ИНД-66 - Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэхжүүлэлт (Шинэчлэгдэж байгаа) /18 хуудас/ 2016 оны NZ amend.5</p>	<p align="center">ИНД-66 - Агаарын Хөлгийн Техник Үйлчилгээний Ажилтны Үнэмлэх, Зэрэглэл (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) /12 хуудас (үндсэн дүрэм-30 хуудастай байсан)/1999 оны NZ amend.1</p>	<p align="center">Тайлбар</p>
<p>А Бүлэг - Ерөнхий зүйл</p>	<p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</p>	
<p>66.1. Хамрах хүрээ Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно: (1) агаарын хөлгийн техник үйлчилгээний үнэмлэх, гэрчилгээ болон зэрэглэл олгох; (2) тухайн үнэмлэх, гэрчилгээ болон зэрэглэлийн эрх, хязгаарлалт.</p>	<p>66.1. Зорилго (а) Энэ дүрмийн зорилго нь агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтанд мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ, зэрэглэл олгоход тавигдах шаардлага, үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээний хүрээнд эдлэх эрх, үүргийг тогтооход оршино.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>66.3. Нэр томьёо ба товчлол Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт багтсан.</p>	<p>66.3. Тодорхойлолт</p>	<p>-Нэр томьёоны тайлбар ИНД-1-д орсон.</p>
<p>66.5. Үнэмлэх болон гэрчилгээ Энэ Дүрмийн дагуу дараах үнэмлэх, гэрчилгээ болон зэрэглэл олгоно: (1) агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн үнэмлэхийг (AMEL) дараах 1, эсхүл хэд хэдэн категориор: (i) нисэх онгоц; (ii) роторт-хөлөг; (iii) хүчний төхөөрөмж; (iv) цахилгаан; (v) хэрэглэл; (vi) радио холбоо; (vii) агаараас хөнгөн агаарын хөлөг; (2) техник үйлчилгээг баталгаажуулах гэрчилгээ (MAC); (3) шалгах эрхийн гэрчилгээ (IAC); (4) Хавсралт В-д заасан бүлгийн зэрэглэл; (5) агаарын хөлөг болон бүрдэл хэсгийн зэрэглэл.</p>	<p>66.5. Үнэмлэх, гэрчилгээ, <u>зэрэглэл</u> (а) Энэ дүрмээр дараах үнэмлэх, гэрчилгээ, зэрэглэлийг олгоно: 1/ техник үйлчилгээний ажилтны дараах ангиллын үнэмлэх: 1.1. онгоц; 1.2. нисдэг тэрэг; 1.3. хүчний төхөөрөмж; 1.4. цахилгаан; 1.5. хэрэглэл; 1.6. радио холбоо; 1.7. агаараас хөнгөн агаарын хөлөг. 2/ техник үйлчилгээг баталгаажуулах гэрчилгээ; 3/ үзлэг хийх гэрчилгээ; 4/ Хавсралт Б –д заасан, бүлэг зэрэглэл; 5/ агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсгийн зэрэглэл.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан -“үзлэг хийх”гэснийг “шалгах эрх” гэж өөрчлөгдсөн -“бүлэг зэрэглэл” гэснийг “бүлгийн зэрэглэл” гэж өөрчлөгдсөн -“бүрэлдэхүүн хэсгийн” гэснийг “бүрдэл хэсгийн” гэж өөрчлөгдсөн</p>

<p>66.7. <u>Үнэмлэх, гэрчилгээ болон зэрэглэл эзэмших хүсэлт гаргах</u></p> <p>(a) AMEL үнэмлэхний нэмэлт <u>категори</u>, эсхүл MAC эзэмших <u>хүсэлт</u> гаргагч нь САА 24066/01 маягтыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт <u>Даргад</u> хүргүүлнэ.</p> <p>(b) IAC эзэмших хүсэлт гаргагч нь САА 24066/03 маягтыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт <u>Даргад</u> хүргүүлнэ.</p> <p>(c) Конвенцийн Хэлэлцэн тохирогч улсаас олгосон хүчинтэй үнэмлэх, эсхүл гэрчилгээг үндэслэн үнэмлэх эзэмших хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (a), эсхүл (b)-гийн шаардлага дээр нэмж тухайн үнэмлэх, эсхүл гэрчилгээгээ <u>Даргад хүргүүлэх үүрэгтэй</u>.</p> <p>(d) AMEL-ийн зэрэглэл авах хүсэлт гаргагч нь САА 24066/02 маягтыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлнэ.</p>	<p>66.7. <u>Өргөдөл гаргах</u></p> <p>(a) Агаарын хөлгийн техник үйлчилгээний <u>ажилтны</u> үнэмлэх, үнэмлэхний нэмэлт <u>ангилал</u>, техник үйлчилгээг баталгаажуулах гэрчилгээ авахаар <u>өргөдөл</u> гаргагч (цаашид Өргөдөл гаргагч гэх) нь ИНЕГ-066/01 маягтыг бөглөж, төлбөрийн баримтын хамт <u>Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид ИНЕГ гэх)-ын даргад</u> ирүүлнэ.</p> <p>(б) Агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсэгт <u>үзлэг хийх</u> гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь ИНЕГ-066/03 маягтыг бөглөж, төлбөрийн баримтын хамт <u>ИНЕГ-ын даргад</u> ирүүлнэ.</p> <p>(в) <u>Өргөдөл</u> гаргагч нь Чикагогийн конвенцийн хэлэлцэн тохирогч <u>аль нэг</u> улсаас олгосон хүчин төгөлдөр үнэмлэх, гэрчилгээтэй бол энэ зүйлийн (a) хэсэг, эсхүл (б) хэсэгт заасан маягтыг бөглөж үнэмлэх, гэрчилгээгээ <u>хавсаргасан байна</u>.</p> <p>(г) Энэ дүрмийн Хавсралт Б-д заасан зэрэглэл авахаар өргөдөл гаргагч нь ИНЕГ- 066/02 маягтыг бөглөж, төлбөрийн баримтын хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>(e) САА 24066/01, САА 24066/02, САА 24066/03 маягт нь дараах мэдээллийг шаардана:</p> <p>(1) хүсэлт гаргагчийн нэр болон Монгол Улсад ажил үүрэг гүйцэтгэх хаяг;</p> <p>(2) тухайн маягтад заасан, хүсэлт гаргагчтай холбоотой Даргын шаардаж болох нэмэлт дэлгэрэнгүй мэдээлэл.</p>	<p><i>2001 онд орхигдуулсан</i></p>	<p>-Орхигдуулсан</p>
<p>66.9. <u>Үнэмлэх, гэрчилгээ болон зэрэглэл олгох</u></p> <p>(a)Хэрэв <u>Дарга</u> дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь энэ Дүрмийн дагуу үнэмлэх, гэрчилгээ, эсхүл зэрэглэл эзэмших эрхтэй:</p> <p>(1) хүсэлт гаргагч нь тохирох зөв хүн байх;</p> <p>(2) хүсэлт гаргагч тухайн үнэмлэх, гэрчилгээ, эсхүл зэрэглэлийн эрх үүргийг хэрэгжүүлэхийн тулд агаарын хөлгийн техник үйлчилгээний <u>баримт бичгийн батлагдсан</u> хэл дээр унших, <u>ярих</u>, ойлгох бүрэн чадвартай байх;</p> <p>(3) хүсэлт гаргагч нь холбогдох Бүлгийн үнэмлэх, гэрчилгээ, <u>эсхүл</u> зэрэглэлийн нөхцөл хангах шаардлагыг хангасан байх;</p>	<p>66.9. <u>Үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээ олгох</u></p> <p>(a) <u>ИНЕГ</u> нь дараах шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид энэ дүрмийн дагуу үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээ олгоно:</p> <p>1/ бие болон эрүүл мэнд, оюун санааны хувьд энэ дүрмийн дагуу үнэмлэх, гэрчилгээ эзэмшихэд нийцтэй этгээд байх, “Тохирох зөв хүнийг тодорхойлох” ИНЕГ-Маягт 02-ыг бөглөсөн байх;</p> <p>2/ үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээний дагуу үүрэг гүйцэтгэхийн тулд <u>монгол (англи)</u> хэлээр унших, ойлгох чадвартай байх;</p> <p>3/ үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээ олгоход холбогдох, энэхүү дүрмийн холбогдох бүлэгт заагдсан шаардлагыг хангасан байх;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>(4) тухайн гэрчилгээ, эсхүл үнэмлэхийг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.</p> <p>(b) Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, үнэмлэх, гэрчилгээ, эсхүл зэрэглэл эзэмших хүсэлт гаргагч нь Конвенцийн Хэлэлцэн тохирогч улсаас олгосон хүчинтэй үнэмлэх, эсхүл гэрчилгээ эзэмшигч гэсэн үндэслэлээр үнэмлэх, эсхүл гэрчилгээ эзэмших эрхтэй:</p> <p>(1) хүсэлт гаргагч нь хүлээн зөвшөөрөхүйц үнэмлэх, эсхүл гэрчилгээ эзэмшигч байх;</p>	<p>4/ үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээ олгосноор нисэхийн аюулгүй ажиллагаанд харшлахгүй байх.</p> <p>(б) ИНЕГ нь Чикагогийн конвенцийн хэлэлцэн тохирогч аль нэг улсаас олгосон хүчин төгөлдөр үнэмлэх гэрчилгээг үндэслэн дараах шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээ олгож болно:</p> <p>1/ өргөдлийг тухайн үнэмлэх, гэрчилгээг эзэмшихээр хүсэлт гаргагч өөрийн биеэр гаргасан байх;</p>	
<p>(2) хүсэлт гаргагч нь тохирох зөв хүн байх;</p>	<p><i>2001 онд орхигдуулсан</i></p>	
<p>(3) тухайн гэрчилгээ, эсхүл үнэмлэхийг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх;</p> <p>(4) хүсэлт гаргагч нь 66.53-(а)-д шаардсан нисэхийн хууль, дүрмийн болон аман шалгалтад тэнцсэн байх.</p>	<p>2/ үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээ олгосноор нисэхийн аюулгүй ажиллагаанд харшлахгүй байх;</p> <p>3/ 66.53-ын (а)-д заасан, Иргэний нисэхийн тухай хуулиар бичгийн болон аман шалгалтуудыг амжилттай өгсөн байх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>(c) ИНЕГ-тай Хамтын ажиллагааны зохицуулалтын гэрээтэй улсын эрх бүхий байгууллагаас олгосон AMEL эзэмшигч нь хэрэв Монгол улсын Иргэний нисэхийн тухай хууль болон Даргын хүлээн зөвшөөрөхүйц аман шалгалтыг амжилттай өгсөн бол, энэ Дүрмийн дагуу олгох үнэмлэх, эсхүл гэрчилгээ эзэмших эрхтэй.</p>	<p>(г) Улсын агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны хүчин төгөлдөр үнэмлэх эзэмшигчийн үнэмлэхийг энэ дүрмийн 66.53-ын (а)-гийн 2/-ын шаардлагыг хангасан тохиолдолд ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрч болно.</p>	
<p>66.11. Үнэмлэх болон гэрчилгээний хугацаа</p> <p>(a) Энэ Дүрмийн дагуу олгосон AMEL нь, түүнийг Хуулийн дагуу түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд, тухайн гэрчилгээ эзэмшигчийн насан түршид хүчинтэй байна.</p> <p>(b) MAC-ийг дараах хугацаагаар олгож болно:</p> <p>(1) 24 сар хүртэл; эсхүл,</p> <p>(2) тухайн агаарын хөлгийн үндсэн зохион бүтээгчид 5 жил хүртэл.</p> <p>(c) IAC-ийг 60 сар хүртэл хугацаагаар олгож болно.</p> <p>(d) Түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосон AMEL, MAC, эсхүл IAC эзэмшигч нь тухайн баримт бичгийг Даргад хүргүүлнэ.</p>	<p>66.11. Үнэмлэхний хугацаа</p> <p>(a) Техник үйлчилгээний ажилтны үнэмлэхийг хугацаагүй олгох бөгөөд Иргэний нисэхийн хуульд заасны дагуу үйлчлэлийг нь түр зогсоох, хүчингүй болгохоос бусад тохиолдолд хүчин төгөлдөр байна.</p> <p>(б) Агаарын хөлгийн техник үйлчилгээг баталгаажуулах гэрчилгээг 24 сар хүртэл хугацаагаар олгож болно.</p> <p><i>2001 онд орхигдуулсан</i></p> <p>(в) Агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсэгт үзлэг хийх гэрчилгээг 5 жилийн хугацаагаар олгож болно.</p> <p>(г) Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх эзэмшигч нь үнэмлэх, гэрчилгээнүүдийн үйлчлэлийг нь түр зогсоох, хүчингүй болгосон тохиолдолд иргэний нисэхийн баримт бичгийг ИНЕГ-ын даргад нэн даруй хүргүүлнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>66.13. Шалгалт</p> <p>(a) Энэ Дүрмийн дагуу үнэмлэх, зэрэглэл, эсхүл гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч бүр нь:</p> <p>(1) шалгалтад орохдоо өөрийгөө нотлох баримт бичигтэй байна;</p> <p>(2) бичгийн шалгалтад тэнцэхийн тулд боломжит үнэлгээний 70%-иас доошгүйг авсан байна;</p> <p>(3) аман шалгалтын хувьд, тухайн шалгалт өгч байгаа сэдвээр ажиллах мэдлэгээ шалгуулна.</p> <p>(b) Нисэхийн хууль, дүрмийн бичгийн шалгалтад тэнцсэн дүн 5 жилийн хугацаанд хүчинтэй байхаас бусад тохиолдолд, бичгийн шалгалтад тэнцсэн сэдвийн дүн насан туршид хүчинтэй байна.</p> <p>(c) Энэ дүрмийн 66.53(а)(3)-т шаардсан аман шалгалтыг өгөхийн тулд хүсэлт гаргагч нь 66.53(а)(2) болон (4)-т заасан бичгийн шалгалт болон туршлагад тавих шаардлагыг хангасан байх үүрэгтэй.</p> <p>(d) Энэ дүрмийн 66.53(а)(2) болон (3)-т шаардсан бичгийн, эсхүл аман шалгалтад 3 удаа тэнцээгүй хүсэлт гаргагч нь сүүлчийн шалгалт өгсөн өдрөөс хойш 3 сарын дотор тухайн шалгалтыг дахин өгөхөөр хандах эрхгүй.</p>	<p>66.13. Шалгалт</p> <p>(a) Өргөдөл гаргагч нь шалгалт өгөхдөө:</p> <p>1/ биеийн байцаалт, бичиг баримтаа авч ирэх;</p> <p>2/ бичгээр өгөх шалгалтанд 80 хувиас доошгүй үнэлгээ авсан байх;</p> <p>3/ аман шалгалтын үед холбогдох сэдвээр өөрийн мэдлэгийг бүх талаар харуулах.</p> <p>(б) Өргөдөл гаргагч нь үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээ авах шалгалтанд амжилттай дүн үзүүлсэн боловч, шалгалт өгсөн өдрөөс хойш 6 сарын дотор холбогдох үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээг эдлээгүй тохиолдолд шалгалтыг дахин өгнө.</p> <p>(в) 66.53-ын (а) хэсгийн 3/-т заасан аман шалгалт өгөхийн тулд өргөдөл гаргагч нь 66.53-ын (а) хэсгийн 2/ ба 4/-т тусгасан бичгийн шалгалт болон мэргэжлийн дадлага туршлагад тавих шаардлагыг хангасан байна.</p> <p>(г) Өргөдөл гаргагч 66.53-ын (а) хэсгийн 3/-т заасан аман шалгалтанд 3 удаа орж хангалтгүй дүн үзүүлсэн тохиолдолд хамгийн сүүлд шалгалт өгсөн өдрөөс хойш 3 сарын дотор дахин шалгалт өгөх эрхгүй.</p>	<p>-Шалгалтын үнэлгээ 80%-иас,70%-иас доошгүй гэж өөрчлөгдсөн</p> <p>- “шалгалт өгсөн өдрөөс хойш 6 сар” гэснийг “5 жилийн хугацаатай насан туршид хүчинтэй” гэж өөрчлөгдсөн</p>
<p>66.15. Шалгалтын үед хориглох зүйл</p> <p>(a) Энэ Дүрмийн дагуу шалгалтын үед, этгээд нь шалгалт авч байгаа ажилтан зөвшөөрснөөс бусад тохиолдолд дараах үйлдлийг хийхгүй:</p> <p>(1) бусад этгээдээс хуулах; эсхүл</p> <p>(2) мэдээллийн зөвшөөрөгдөөгүй эх үүсвэр ашиглах; эсхүл</p> <p>(3) шалгалт авч байгаа ажилтнаас бусад этгээдтэй аливаа арга замаар харьцах; эсхүл</p> <p>(4) бусдын өмнөөс шалгалт өгөх; эсхүл</p> <p>(5) шалгалт авч байгаа этгээд зөвшөөрснөөс бусад тохиолдолд, бичмэл, эсхүл хэвлэмэл материалыг шалгалтын өрөөнөөс авч гарах; эсхүл</p> <p>(6) шалгалтын үед түгээсэн цахим, бичмэл, эсхүл хэвлэмэл материалыг аливаа арга хэлбэрээр, эсхүл хэрэгсэл ашиглан хуулбарлах; эсхүл</p> <p>(7) шалгалтын өрөөнд зөвшөөрөгдөөгүй материал авч орох.</p>	<p>66.15. Шалгалтын үед хориглох зүйлс</p> <p>(a) Энэ дүрмийн дагуу авч буй шалгалтын үед дараах үйлдлийг хориглоно:</p> <p>1/ бусдаас хуулах;</p> <p>2/ аливаа мэдээллийн эх үүсвэрээс хуулбарлах;</p> <p>3/ шалгалт авч байгаа этгээдээс бусад аливаа этгээдтэй ямар нэгэн хэлбэрээр харьцах;</p> <p>4/ бусдын өмнөөс шалгалт өгөх;</p> <p>5/ шалгалтын материалыг гадагш авч гарах;</p> <p>6/ ямар нэгэн хэрэгсэл ашиглан шалгалтын талаар болон шалгалтын материалаас бичлэг хийх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>(b) Энэ зүйлийн (a)-д заасан аль нэг үйлдлийг хийсэн этгээдэд <u>Дарга</u> дараах арга хэмжээг бүгдийг <u>эсхүл хэсэгчлэн</u> оноож болно:</p> <p>(1) тухайн сэдвийн шалгалтад тэнцээгүйд тооцох;</p> <p>(2) <u>өмнө нь тэнцсэн шалгалтын сэдвийг бүгдийг, эсхүл хэсэгчлэн хүчингүйд тооцох;</u></p> <p>(3) цаашид ИНД-ийн дагуу өгөх шалгалтад 12 сар хүртэл хугацаанд <u>оруулахгүй байх;</u></p> <p>(4) тухайн этгээдэд энэ Дүрмийн дагуу олгосон үнэмлэх, гэрчилгээ, эсхүл зэрэглэлийг <u>түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох.</u></p>	<p>(б) Энэ зүйлийн (a) хэсэгт заасан үйлдлийг гаргасан этгээдийн талаар <u>ИНЕГ</u> дараах шийдвэрийн <u>аль нэгийг</u> гаргана:</p> <p>1/ тухайн шалгалтанд тэнцээгүйд тооцох;</p> <p>2/ ИНД-ийн хүрээнд өгөх аливаа шалгалтанд орох эрхийг нь 12 сар хүртэл хугацаагаар <u>хасах;</u></p> <p>3/ энэ дүрмийн дагуу олгосон аливаа үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээг хураах, эсхүл үйлчлэлийг нь <u>түр зогсоох.</u></p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>66.17. Согтууруулах ундаа, эсхүл <u>эмийн бодистой холбоотой гэмт хэрэг</u></p> <p>Согтууруулах ундаа, эсхүл эмийн бодис хэрэглэсэн эсэхийг тогтоох хуулийн дагуух тест өгөхөөс татгалзсан үйлдлийг багтаасан, согтууруулах ундаа, эсхүл эмийн бодистой холбоотой шүүхийн шийтгэл нь тухайн этгээдийг үнэмлэх эзэмшихэд тохирох зөв хүн хэвээр байгаа эсэхийг дахин тогтоох үндэслэл болно. <u>Тухайн шийтгэл нь үнэмлэх олгохоос татгалзах, эсхүл түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоход нөлөөлж болно.</u></p>	<p>66.17. <u>Мансууруулах бодис, согтууруулах ундаа хэрэглэсэн ажилтанд хүлээлгэх хариуцлага</u></p> <p>(a) Техник үйлчилгээний ажилтан ажлын байранд мансууруулах бодис, согтууруулах ундаа хэрэглэсэн тохиолдолд тухайн ажилтны үнэмлэхийг хураах буюу үйлчлэлийг нь түр түдгэлзүүлэх арга хэмжээ авна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Мансууруулах бодис-эмийн бодис</p>
<p>66.19. <u>Эрүүл мэндийн шаардлага</u></p> <p>Энэ Дүрмийн дагуу олгосон үнэмлэх, эсхүл гэрчилгээ эзэмшигч нь өөрт болон бусад этгээдэд хохирол учруулж болох эрсдэл үүсгэх эрүүл мэндийн дутагдалтай, эсхүл тухайн <u>дутагдал нь даамжирч байгаа бол</u>, үнэмлэх, эсхүл гэрчилгээний эрхийг хэрэгжүүлэхгүй.</p>	<p>66.19. <u>Техник үйлчилгээний ажилтны эрүүл мэндэд тавигдах шаардлага</u></p> <p>(a) Техник үйлчилгээний ажилтны үнэмлэх эзэмшигч (цаашид үнэмлэх эзэмшигч гэх) нь өөрийн эрүүл мэндийн байдал муудсан, эсхүл <u>муудаж байгаагаа мэдсэн тохиолдолд</u>, өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах үүднээс тухайн үнэмлэхний дагуу олгогдсон аливаа <u>эрхээс сайн дураар татгалзана.</u></p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>В Бүлэг - Агаарын хөлгийн техник үйлчилгээний <u>инженерийн үнэмлэх</u></p>	<p>Б БҮЛЭГ. АГААРЫН ХӨЛГИЙН ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭНИЙ <u>АЖИЛТНЫ ҮНЭМЛЭХ</u></p>	
<p>66.51. Хамрах хүрээ</p> <p>Энэ Бүлэг нь AMEL олгох, тухайн үнэмлэхний эрх, хязгаарлалт болон туршлага хадгалах зохицуулалтын шаардлагыг тогтооно.</p>	<p>66.51. Нөөц</p> <p><i>2001 онд орхигдуулсан</i></p>	

66.53. Нөхцөл хангах шаардлага

(a) AMEL эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) 21 нас хүрсэн байх;
- (2) нисэхийн хууль, дүрмийн шалгалтыг багтаасан бичгийн шалгалт, эсхүл тэдгээртэй дүйцэх дараах шалгалтад тэнцсэн байх:
 - (i) Даргын хүлээн зөвшөөрөхүйц;
 - (ii) хүсэлт гаргасан үнэмлэхний категорийн агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн үүрэг, хариуцлагатай холбоотой;

66.53. Үнэмлэх авахад тавигдах шаардлага

(a) Өргөдөл гаргагч нь дараах шаардлагуудыг хангасан байна:

- 1/ 18 нас хүрсэн байх;
- 2/ дараах сэдвүүдээр амжилттай шалгагдсан байна:

2.1. иргэний нисэхийн хууль тогтоомж ба нислэгт тэнцэх чадварын шаардлагууд: Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх эзэмшигчид холбогдолтой хууль, дүрмүүд, агаарын хөлгийг гэрчилгээжүүлэх ба нислэгт тэнцэх чадварын хадгалалттай холбоотой дүрмүүд, зөвшөөрөгдсөн техник үйлчилгээний байгууллагын зааврууд;

2.2. Байгалийн шинжлэх ухаан ба агаарын хөлгийн тухай ерөнхий мэдлэг: Ерөнхий математик, хэмжих нэгж, агаарын хөлгийн техник үйлчилгээнд хамаарах физик, химийн онол ба физик, химийн үндсэн хуулиуд;

2.3. Агаарын хөлгийн инженеринг: Агаарын хөлгийн хийцийн материалын шинж чанар ба хэрэглээ, агаарын хөлгийн их биеийн бүтцийн зарчим ба гүйцэтгэх үүргүүд, хадлагын технологи, хүчний төхөөрөмж /хөдөлгүүр/ ба түүний системүүд, механик, шингэний систем, цахилгаан ба электрон хүчдэл үүсгүүрүүд, агаарын хөлгийн хэрэглэл ба дэлгэцийн системүүд, агаарын хөлгийн удирдлагын системүүд, агаарын навигаци ба холбооны систем;

2.4. Агаарын хөлгийн техник үйлчилгээ: Зохих нислэгт тэнцэх чадварын стандарт болон холбогдох техник үйлчилгээний зааварт тусгасан аргачлалын дагуу агаарын хөлгийн их бие, бүрэлдэхүүн хэсэг ба системүүдийн дутагдлыг арилгах, хийцийг өөрчлөх, эд ангийг солих, үзлэг шалгалт, засвар, их засвар зэргийг агуулсан агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын хадгалалтыг бататгах ажлууд;

2.5. Хүний чадавхи: Агаарын хөлгийн техник үйлчилгээтэй холбоотой хүний чадавхи.

-Орчуулга, найруулга зассан

-Original дүрэмд 21нас байсныг хэвээр үлдээсэн

-3Ц-ийн шаардлагыг тайлбарласан

(3) AMEL эзэмшигчийн хэрэгжүүлэх үүрэг, хариуцлагын талаарх тухайн этгээдийн ойлголт болон практик хэрэглээ хамарсан аман шалгалтад тэнцсэн байх;

(4) дараах аль нэг сургалт, дадлагад амжилттай хамрагдсан байх:

3/ аман шалгалт (үнэмлэх эзэмшигчийн хүлээх үүрэг, хариуцлагыг ухамсарласан байдал болон өөрийн дадлага туршлагын талаар)-д хангалттай дүн үзүүлсэн байх;

4/ мэргэжил, дадлагын хувьд дараах шаардлагуудын аль нэгийг хангасан байх:

<p>(i) <u>нисэхийн мэргэжлийн техникийн сургуульд</u> хийх сургалт дадлагаар агаарын хөлгийн хүчилсэн бүтэц, хүчний төхөөрөмж, эсхүл авионикийн төхөөрөмжийн үйлдвэрлэл, техник үйлчилгээ, эсхүл модификацид өргөн ашигладаг үйл ажиллагааны журам, дадлага, материал, багаж, машин-багаж болон төхөөрөмжийг хамарсан албан ёсны техникийн сургалтыг багтаасан, нисэхийн холбоотой ажлын <u>48 сарын</u> дадлага туршлагыг аль ч цаг хугацаанд хуримтлуулсан байх; эсхүл</p>	<p style="text-align: center;"><i>2001 онд орхигдуулсан</i></p>	<p>Жишээ нь Механик, тээврийн сургууль төгссөн хүмүүсийг, хэрэв сургалтын хөтөлбөр нь энэ шаардлагыг хангасан гэж үзвэл сурч байх хугацаандаа 48 сарын дадлага туршлагыг хангасан гэж үзэх баримт байгаа бол төгсөөд AMEL авах боломжтой болно.</p>
<p>(ii) <u>нисэхийн бус, холбогдох мэргэжлийн техникийн сургуульд</u> хийх сургалт болон тухайн сургалт дууссаны дараа, агаарын хөлгийн хүчилсэн бүтэц, хүчний төхөөрөмж, эсхүл авионикийн төхөөрөмжийн үйлдвэрлэл, техник үйлчилгээ, эсхүл модификацид өргөн ашигладаг үйл ажиллагааны журам, дадлага, материал, багаж, машин-багаж болон төхөөрөмжийг хамарсан, нисэхийн холбоотой ажлын <u>36 сарын</u> дадлага туршлага хуримтлуулсан байх; эсхүл</p>	<p style="text-align: center;"><i>2001 онд орхигдуулсан</i></p>	<p>Бусад техникийн сургууль төгссөн хүмүүс тухайн байгууллагад 36 сар (ii)-т заасан дадлага, туршлагыг хуримтлуулсан бол AMEL авах боломжтой болно.</p>
<p>(iii) энэ зүйлийн (4)(i)-(ii) болон (iv)-т шаардсан сургалтад хамрагдаагүй боловч, агаарын хөлгийн хүчилсэн бүтэц, хүчний төхөөрөмж, эсхүл авионикийн төхөөрөмжийн үйлдвэрлэл, техник үйлчилгээ, эсхүл модификацид өргөн ашигладаг үйл ажиллагааны журам, дадлага, материал, багаж, машин-багаж болон төхөөрөмжийг хамарсан, нисэхийн холбоотой ажлын <u>60 сарын</u> дадлага туршлагатай байх; эсхүл</p>	<p>4.2. <u>бие даан суралцах замаар</u>, агаарын хөлгийн их бие, хөдөлгүүр, эсхүл холбооны тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, өөрчлөлтийг хийхэд ашиглагддаг багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал дээр <u>48 сараас</u> доошгүй хугацаагаар дадлагажсан байх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>- Дадлага туршлагыг “48 сараас” гэснийг “60 сарын” гэж өөрчлөгдсөн</p>
<p>(iv) Иргэний нисэхийн тухай хууль болон ИНД-141, эсхүл ИНД-147-гийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн зохион байгуулсан, хяналттай сургалт болон дадлагыг багтаасан <u>36 сараас</u> доошгүй хугацаатай цогц сургалтын курс, хэрэв гэрчилгээ нь тухайн сургалтын курсийг зохион байгуулахыг зөвшөөрсөн бол.</p>	<p>4.1. <u>ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн</u> иргэний нисэхийн сургалтын байгууллагаас зохион байгуулсан зөвшөөрөгдсөн цогц сургалтанд хамрагдаж, <u>24 сараас</u> доошгүй хугацаанд дадлагажсан байх; эсхүл</p>	<p>-“24 сараас” гэснийг-“36 сараас” гэж өөрчлөгдсөн</p>

<p>(b) Энэ зүйлийн (a)(4)-т заасан нөхцөлийн хувьд, шаардлагатай 24 сарын туршлага нь хүсэлт гаргасан үнэмлэхний категорид тохирсон байна.</p> <p>(c) Хэрэв AMEL эзэмшигч нь энэ зүйлийн (a)(2)-т шаардсан зохих шалгалтад тэнцсэн ба дараах шаардлагыг хангасан бол, тухайн үнэмлэхэнд нэмэлт категори авах эрхтэй:</p> <p>(1) хүсэлт гаргасан үнэмлэхний категорид тохирох ажлын 24 сарын туршлагатай байх; эсхүл</p> <p>(2) хүсэлт гаргасан үнэмлэхний категорид тохирох ажлын 12 сарын туршлагатай байх, хэрэв хүсэлт гаргагч нь 10 жил, эсхүл түүнээс дээш хугацаанд AMEL-ийн эрхийг хэрэгжүүлсэн бол.</p>	<p>(б) Үнэмлэх эзэмшигч ангилал болон нэмэлт ангилал эзэмшихийг хүсвэл энэ зүйлийн (a) хэсгийн 2/-т заасан шалгалтыг өгсөн байхын хамт, мөн дараах шаардлагуудыг хангасан байна:</p> <p>1/ тухайн ангилалд нийцэх 24 сарын ажлын дадлага, туршлагатай байх, эсхүл</p> <p>2/ техник үйлчилгээний ажилтны үнэмлэх авснаас хойш 5 болон түүнээс дээш жил ажилласан тохиолдолд тухайн ангилалд нийцэх 12 сарын ажлын дадлага, туршлагатай байх.</p> <p>(в) Өргөдөл гаргагч нь үнэмлэхний дагуу олгогдох эрхийг хэрэгжүүлэх мэргэжлийн чадавхитай гэдгээ харуулна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>66.55. Эрх, хязгаарлалт</p> <p>(a) Энэ зүйлийн (b), (c) болон ИНД-145.5-ын шаардлагыг харгалзан, AMEL нь тухайн эзэмшигчид дараах эрхийг олгоно:</p> <p>(1) агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн техник үйлчилгээг гүйцэтгэх, эсхүл хяналт тавих;</p> <p>(2) техник үйлчилгээний дараа агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэх.</p> <p>(b) AMEL эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан бөгөөд тухайн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн мэдлэгтэй байхаас бусад тохиолдолд, тухайн үнэмлэхний эрхийг агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэгт хэрэгжүүлэхгүй:</p> <p>(1) тухайн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн хувьд, Хавсралт В-д заасан холбогдох бүлгийн, эсхүл маягийн зэрэглэл эзэмшдэг байх; эсхүл</p> <p>(2) тухайн эрх нь Хавсралт С-д заагдсан нэмэлт эрх байх.</p> <p>(c) AMEL эзэмшигч нь тухайн төхөөрөмжийг ашиглах сургалтад хамрагдсаныг нотлох баримттайгаас бусад тохиолдолд, тусгай тестийн төхөөрөмж ашиглахыг шаардсан, Хавсралт С-д заасан нэмэлт эрхийг хэрэгжүүлэхгүй.</p>	<p>66.55. Эрх, үүрэг</p> <p>(a) Үнэмлэх эзэмшигч нь энэ зүйлийн (б), (в) болон ИНД-145-ын шаардлагаас хамаарч дараах эрхийг эдлэнэ:</p> <p>1/ агаарын хөлөг, эсхүл түүний бүрэлдэхүүн хэсгийн техник үйлчилгээг гүйцэтгэх, эсхүл хянах, болон;</p> <p>2/ техник үйлчилгээний дараа агаарын хөлөг, эсхүл түүний бүрэлдэхүүн хэсгийг техник үйлчилгээнээс гаргах.</p> <p>(б) Үнэмлэх эзэмшигч нь тухайн агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсгийн талаар ойлголт мэдлэггүй, мөн дараах шаардлага хангагдаагүй тохиолдолд тухайн агаарын хөлөг, эсхүл түүний бүрэлдэхүүн хэсэг дээр аливаа эрх эдлэхгүй:</p> <p>1/ тухайн агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсгийн хувьд Хавсралт В-д заагдсан зохих маягийн, эсхүл бүлгийн зэрэглэлгүй, эсхүл</p> <p>2/ Хавсралт В-д заасан нэмэлт эрхгүй бол.</p> <p>(в) Үнэмлэх эзэмшигч нь тусгай зориулалтын шалгах тоног төхөөрөмжийг ашиглах сургалтанд хамрагдаагүй бол хавсралт В-д заасан, тусгай зориулалтын шалгах тоног төхөөрөмж шаардагдах нэмэлт эрхийг эдлэхгүй.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Утгын алдаа, найруулга зассан</p>
<p>66.57. Туршлага хадгалах шаардлага</p> <p>AMEL эзэмшигч нь өмнө үргэлжилсэн 24 сарын дотор дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, тухайн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлэхгүй:</p> <p>(1) 6 сараас доошгүй хугацаанд:</p> <p>(i) тухайн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлсэн байх; эсхүл</p> <p>(ii) эзэмшиж байгаа зэрэглэлд хамаарах агаарын хөлгийн техник үйлчилгээнд хяналт тавьж, удирдан зохион</p>	<p>66.57. Дадлага туршлагад тавигдах шаардлага</p> <p>(a) Үнэмлэх эзэмшигч нь өмнөх 24 сарын туршид дараах шаардлагуудыг хангасан тохиолдолд үнэмлэхний дагуу олгогдох эрхийг эдлэнэ:</p> <p>1/ 6 ба түүнээс дээш сарын хугацаанд:</p> <p>1.1. үнэмлэхний дагуу олгогдох эрхийг эдлэсэн; эсхүл</p> <p>1.2. олгогдсон зэрэглэлийн хүрээнд агаарын хөлгийн техник үйлчилгээнд хяналт тавьж ажилласан; эсхүл</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p><u>байгуулсан байх</u>; эсхүл (iii) эзэмшиж байгаа зэрэглэлд хамаарах техникийн сургалтад багшлах ажлыг гэрчилгээжсэн сургалтын байгууллагад гүйцэтгэсэн байх; эсхүл</p>	<p>2/ олгогдсон зэрэглэлд хамаарах зөвшөөрөгдсөн сургалт дадлагыг гэрчилгээжсэн сургалт дадлагын байгууллага дээр гүйцэтгэсэн.</p>	
<p>(iv) энэ зүйлийн (i)-(ii)-(iii)-т заасан ажлын аль алинд нь оролцсон байх; эсхүл</p>	<p><i>2001 онд орхигдуулсан.</i></p>	
<p>(2) AMEL эзэмшигчийн хэрэгжүүлэх үүрэг, хариуцлагын талаарх тухайн этгээдийн <u>ойлголт болон практик хэрэглээг</u> хамарсан аман шалгалтад <u>тэнцсэн</u> байх.</p>	<p>3/ үнэмлэх эзэмшигчийн хүлээх үүрэг, хариуцлагыг ухамсарласан байдлын талаарх аман шалгалтад <u>хангалттай дүн үзүүлсэн.</u></p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>С Бүлэг - Агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн зэрэглэл</p>	<p>В БҮЛЭГ. АГААРЫН ХӨЛГИЙН ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ ЗЭРЭГЛЭЛ</p>	
<p>66.101. Хамрах хүрээ Энэ Бүлэг нь агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн бүлгийн зэрэглэл болон агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн маягийн зэрэглэлд тавих зохицуулалтын шаардлагыг тогтооно.</p>	<p>66.101. Нөөц <i>2001 онд орхигдуулсан.</i></p>	
<p>66.103. <u>Нөхцөл хангах</u> шаардлага Агаарын хөлгийн техник үйлчилгээний инженерийн бүлгийн, эсхүл маягийн зэрэглэл <u>эзэмших этгээд нь</u> дараах шаардлагыг хангасан байна: (1) <u>тохирох категорийг хүчинтэй</u> AMEL эзэмшдэг байх; (2) хүсэлт гаргасан зэрэглэлийн хувьд, агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн маяг, эсхүл <u>бүлгээр ажилласан</u> 6 сарын дадлага туршлагатай байх; (3) дараах сургалт, шалгалтад амжилттай хамрагдсан байх; (i) <u>Даргын</u> хүлээн зөвшөөрөхүйц шалгалт; эсхүл (ii) хүсэлт гаргасан зэрэглэлийн агаарын хөлгийн маяг, эсхүл бүрдэл хэсэгтэй холбоотой дараах сургалтын курс: (А) Иргэний нисэхийн тухай хууль болон ИНД-141, <u>эсхүл ИНД-147-гийн</u> дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн зохион байгуулсан, <u>хэрэв гэрчилгээ нь тухайн сургалтын курсийг зохион байгуулахыг зөвшөөрсөн бол; эсхүл</u> (В) хамааралтай агаарын хөлөг, эсхүл <u>бүрдэл хэсгийн</u> үйлдвэрлэгчийн зохион байгуулсан; эсхүл (С) Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагын</p>	<p>66.103. <u>Зэрэглэл авахад тавигдах</u> шаардлага (а) Энэ дүрмийн дагуу Хавсралт Б-д заасан маягийн, эсхүл бүлгийн зэрэглэл авахаар <u>өргөдөл гаргагч нь</u> дараах шаардлагуудыг хангасан байна: 1/ агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэхтэй байх; ба 2/ олгогдох зэрэглэлийн хувьд тухайн маяг, эсхүл бүлгийн агаарын хөлөг, түүний <u>бүрэлдэхүүн хэсэг</u> дээр 6 сараас доошгүй хугацаагаар ажилласан дадлага, туршлагатай байх; 3/ энэхүү шаардлагын хүрээнд; 3.1. <u>ИНЕГ-аас</u> авах шалгалтанд хангалттай дүн үзүүлсэн байх; эсхүл, 3.2. тухайн зэрэглэлийн хувьд агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсгийн маягт хамааралтай дараах аль нэг сургалтанд хамрагдсан байх: 3.2.1. <u>ИНД-141-ийн</u> дагуу гэрчилгээжсэн иргэний нисэхийн сургалтын байгууллагаас зохион байгуулсан сургалтанд; эсхүл 3.2.2. тухайн агаарын хөлөг, түүний <u>бүрэлдэхүүн хэсгийн</u> үйлдвэрлэгчээс зохион байгуулсан сургалтанд; эсхүл</p>	<p>-Орчуулга, найруулга зассан -“Зэрэглэл авах” гэснийг “Нөхцөл хангах” гэж өөрчлөгдсөн</p>

<p>зөвшөөрсөн.</p>	<p>3.2.3. хэлэлцэн тохирогч <u>аль нэг</u> улсын эрх бүхий байгууллагаас зөвшөөрөгдсөн сургалтанд.</p>	
<p>66.105. Эрх (a) Бүлгийн зэрэглэл нь <u>AMEL</u> эзэмшигчид, тухайн үнэмлэхний эрхийг, Хавсралт В-гийн хамаарах бүлгийн тодорхойлолтод багтсан агаарын хөлөг, эсхүл <u>бүрдэл</u> хэсэгт хэрэгжүүлэх эрхийг олгоно. (b) ИНД-145.5-ын шаардлагыг харгалзан, маягийн зэрэглэл нь <u>AMEL</u> эзэмшигчид, тухайн зэрэглэлд заасан агаарын хөлгийн маяг, эсхүл бүрдэл хэсэгт тухайн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлэх <u>эрх</u> олгоно.</p>	<p>66.105. <u>Зэрэглэлийн дагуу олгогдох эрх</u> (a) Бүлгийн зэрэглэл нь <u>үнэмлэх</u> эзэмшигчид тухайн үнэмлэхээр олгогдсон эрхийг энэхүү дүрмийн Хавсралт Б-д тусгагдсан зохих бүлэгт хамаарах аливаа агаарын хөлөг, түүний <u>бүрэлдэхүүн</u> хэсэг дээр эдлэх зөвшөөрлийг олгоно. (б) ИНД-145-д заасан шаардлагын хүрээнд, маягийн зэрэглэл нь <u>үнэмлэх</u> эзэмшигчид тухайн үнэмлэхээр олгогдсон эрхийг тухайн зэрэглэлд хамаарах маягийн агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсэг дээр эдлэх <u>зөвшөөрлийг</u> олгоно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>D Бүлэг - Техник үйлчилгээг баталгаажуулах гэрчилгээ</p>	<p>Г БҮЛЭГ. ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭГ БАТАЛГААЖУУЛАХ ГЭРЧИЛГЭЭ</p>	
<p>66.151. <u>Хамрах хүрээ</u> Энэ Бүлэг нь МАС олгох болон тухайн гэрчилгээний эрх, хязгаарлалтад тавих зохицуулалтын шаардлагыг тогтооно.</p>	<p>66.151. <u>Бүлгийн хэрэглээ</u> (a) Энэхүү бүлгийн дагуу олгогдох гэрчилгээ нь зохих түвшинд бэлтгэгдсэн аливаа этгээдэд тухайн гэрчилгээнд заагдсан эрхийн хүрээнд агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсгийн техник үйлчилгээг гүйцэтгэх болон техник үйлчилгээнээс гаргах зөвшөөрөл олгоно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>66.153. <u>Нөхцөл хангах</u> шаардлага MAC эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>(1) хүсэлт гаргасан MAC-ийн хувьд, агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн тодорхой маяг, эсхүл бүлгээр ажилласан <u>Даргын</u> хүлээн зөвшөөрөхүйц дадлага туршлагатай байх;</p> <p>(2) хүсэлт гаргасан MAC-ийн хувьд, агаарын хөлөг, эсхүл <u>бүрдэл</u> хэсгийн тодорхой маяг, эсхүл бүлгээр:</p> <p>(i) <u>Даргын</u> хүлээн зөвшөөрөхүйц сургалтын курсийг <u>амжилттай дүүргэсэн</u> байх; эсхүл</p> <p>(ii) <u>нисэхийн хууль, дүрмийн</u> шалгалтыг багтаасан, Даргын хүлээн зөвшөөрөхүйц шалгалтад тэнцсэн байх.</p>	<p>66.153. <u>Гэрчилгээ авахад тавигдах</u> шаардлага (a) Агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсгийн техник үйлчилгээг баталгаажуулах гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь дараах шаардлагуудыг хангасан байна:</p> <p>1/ техник үйлчилгээг баталгаажуулах гэрчилгээ олгогдох тодорхой маягийн, эсхүл бүлгийн агаарын хөлөг, эсхүл бүрэлдэхүүн хэсгийн хувьд <u>ИНЕГ-ын</u> даргын хүлээх зөвшөөрөх ажлын дадлага туршлагатай байх, ба</p> <p>2/ техник үйлчилгээг баталгаажуулах гэрчилгээ олгогдох тодорхой маягийн, эсхүл бүлгийн агаарын хөлөг, эсхүл <u>бүрэлдэхүүн</u> хэсгийн хувьд:</p> <p>2.1. <u>ИНЕГ-ын даргаас</u> хүлээн зөвшөөрсөн сургалтанд <u>амжилттай хамрагдсан</u> байх; эсхүл</p> <p>2.2. <u>иргэний нисэхийн тухай хуулийн холбогдох заалтуудаас тусгасан</u>, ИНЕГ-ын даргаас хүлээн зөвшөөрсөн шалгалтанд амжилттай дүн үзүүлсэн байх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>66.155. Эрх (a) MAC-д тухайн гэрчилгээ эзэмшигчийн <u>хэрэгжүүлж</u> болох эрхийг заана.</p> <p>(b) MAC нь дараах эрхийг олгоно:</p> <p>(1) AMEL эзэмшигч нь 66.103(2)-т шаардсан дадлага туршлагагүй бол агаарын хөлгийн маягт техник үйлчилгээ <u>гүйцэтгэж, ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх</u>; эсхүл</p> <p>(2) тухайн этгээд нь AMEL эзэмшигч биш боловч, <u>Дарга</u> тухайн этгээдийг ур чадвартай гэж үзвэл, дараах техник үйлчилгээг гүйцэтгэх, эсхүл хяналт тавих:</p> <p>(i) тухайн гэрчилгээнд заасан техник үйлчилгээг агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэгт гүйцэтгэх болон тухайн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх; эсхүл</p> <p>(ii) ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу олгосон тусгай категорийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй агаарын хөлгийн техник үйлчилгээг <u>гүйцэтгэх, ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх</u>.</p>	<p>66.155. Эрх, <u>үүрэг</u> (a) Техник үйлчилгээг <u>баталгаажуулах</u> гэрчилгээ олгогдсон этгээд нь дараах эрхийг эдлэнэ:</p> <p>1/ агаарын хөлгийн аливаа маягийн хувьд үнэмлэх эзэмшигч нь энэ дүрмийн 66.103 –ын 2/-оор шаардсан шаардлагыг хангаагүй боловч тухайн маягийн агаарын хөлгийн техник үйлчилгээг гүйцэтгэх, <u>техник үйлчилгээнээс гаргах</u>; эсхүл</p> <p>2/ энэ дүрмийн дагуу техник үйлчилгээний ажилтны үнэмлэх эзэмшдэггүй ч <u>ИНЕГ-ын</u> даргаас дараахийг гүйцэтгэх, эсхүл хяналт тавих чадвартай гэж дүгнэгдсэн аливаа этгээдийн хувьд:</p> <p>2.1. гэрчилгээ олгогдох агаарын хөлөг, эсхүл бүрэлдэхүүн хэсгийн техник үйлчилгээг гүйцэтгэх болон тэдгээрийг техник үйлчилгээнээс гаргах, эсхүл</p> <p>2.2. ИНД-21-ийн дагуу олгогдсон тусгай ангиллын, туршилтын нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй агаарын хөлгийн техник үйлчилгээг гүйцэтгэх, <u>техник үйлчилгээнээс гаргах</u>.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>Е Бүлэг-<u>Шалгах эрхийн</u> гэрчилгээ</p>	<p>Д БҮЛЭГ. АГААРЫН ХӨЛӨГ, ТҮҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГТ <u>ҮЗЛЭГ ХИЙХ</u> ГЭРЧИЛГЭЭ</p>	

<p>66.201. Хамрах хүрээ Энэ Бүлэг нь IAC олгох болон тухайн гэрчилгээний эрх, хязгаарлалтад тавих зохицуулалтын <u>шаардлагыг</u> тогтооно.</p>	<p>66.201. Бүлгийн хэрэглээ (а) Энэхүү бүлэг нь, агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсэгт үзлэг хийх этгээдэд гэрчилгээ олгох, түүний эрх хязгаарлалтыг <u>тогтоох</u> бөгөөд дараах ажил үүргийг гүйцэтгэх этгээдэд хамаарна:</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>66.203. <u>Нөхцөл хангах</u> шаардлага IAC эзэмших этгээд нь <u>дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:</u></p> <p>(1) энэ Дүрмийн дагуу олгосон, нисэх онгоц болон хүчний төхөөрөмжийн категори, эсхүл роторт-хөлөг болон хүчний төхөөрөмжийн <u>категорийн аль алинаар</u> зэрэглэлтэй AMEL эзэмшдэг ба <u>хүсэлт</u> гаргах үедээ: (i) тухайн үнэмлэхийг 60 сараас доошгүй хугацаагаар эзэмшсэн байх; (ii) 66.57-д заасан туршлага хадгалах шаардлагыг 60 сараас доошгүй хугацаанд хангасан байх.</p> <p>(2) өмнө үргэлжилсэн 24 сарын хугацаанд: (i) AMEL-ийн эрхийг хэрэгжүүлсэн байх; эсхүл (ii) агаарын хөлгийн техник үйлчилгээнд хяналт тавьж, <u>удирдан зохион байгуулсан</u> байх.</p> <p>(3) агаарын хөлгийн хүчилсэн бүтцийн их засвартай холбоотой Даргын хүлээн зөвшөөрөхүйц шалгалтад тэнцсэн байх.</p> <p>(4) дараах этгээдийн зохион байгуулсан зааварчилгааны сургалтын курсийг амжилттай дүүргэж, агаарын хөлөг болон бүрдэл хэсэг нь ИНД-ийн шаардлагыг хангаж байгааг тогтоох үзлэг шалгалт хийх бичгийн шалгалтад тэнцсэн байх: (i) <u>ИНД-147-гийн дагуу олгосон техник үйлчилгээний сургалтын байгууллагын гэрчилгээ, эсхүл техник үйлчилгээний сургалтын байгууллагын хязгаарлагдмал гэрчилгээ эзэмшигчийн; эсхүл</u> (ii) <u>Даргын.</u></p>	<p>1/ <u>ИНД-43 дагуу нислэгт тэнцэх чадварын жилийн үзлэгийг хийх болон бататгах;</u> 2/ <u>үндсэн өөрчлөлт болон үндсэн засварын ажлын дараа техникийн өгөгдлүүдтэй нийцүүлэн бататгах.</u></p>	<p>-66.205-д тусгагдсан</p>
<p>66.203. <u>Нөхцөл хангах</u> шаардлага IAC эзэмших этгээд нь <u>дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:</u></p> <p>(1) энэ Дүрмийн дагуу олгосон, нисэх онгоц болон хүчний төхөөрөмжийн категори, эсхүл роторт-хөлөг болон хүчний төхөөрөмжийн <u>категорийн аль алинаар</u> зэрэглэлтэй AMEL эзэмшдэг ба <u>хүсэлт</u> гаргах үедээ: (i) тухайн үнэмлэхийг 60 сараас доошгүй хугацаагаар эзэмшсэн байх; (ii) 66.57-д заасан туршлага хадгалах шаардлагыг 60 сараас доошгүй хугацаанд хангасан байх.</p> <p>(2) өмнө үргэлжилсэн 24 сарын хугацаанд: (i) AMEL-ийн эрхийг хэрэгжүүлсэн байх; эсхүл (ii) агаарын хөлгийн техник үйлчилгээнд хяналт тавьж, <u>удирдан зохион байгуулсан</u> байх.</p> <p>(3) агаарын хөлгийн хүчилсэн бүтцийн их засвартай холбоотой Даргын хүлээн зөвшөөрөхүйц шалгалтад тэнцсэн байх.</p> <p>(4) дараах этгээдийн зохион байгуулсан зааварчилгааны сургалтын курсийг амжилттай дүүргэж, агаарын хөлөг болон бүрдэл хэсэг нь ИНД-ийн шаардлагыг хангаж байгааг тогтоох үзлэг шалгалт хийх бичгийн шалгалтад тэнцсэн байх: (i) <u>ИНД-147-гийн дагуу олгосон техник үйлчилгээний сургалтын байгууллагын гэрчилгээ, эсхүл техник үйлчилгээний сургалтын байгууллагын хязгаарлагдмал гэрчилгээ эзэмшигчийн; эсхүл</u> (ii) <u>Даргын.</u></p>	<p>66.203. Үзлэг хийх гэрчилгээ олгоход тавигдах шаардлага (а) Агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсэгт үзлэг хийх гэрчилгээ авахаар өргөдөл гаргагч нь дараах <u>шаардлагуудыг хангасан байна:</u></p> <p>1/ энэ дүрмийн дагуу онгоц ба хөдөлгүүр, эсхүл нисдэг тэрэг ба хөдөлгүүрийн <u>ангиллаар</u> үнэмлэх олгогдсон байх ба <u>өргөдөл</u> гаргах үедээ: 1.1. уг үнэмлэхийг 60 сараас доошгүй хугацаагаар эзэмшсэн байх; 1.2. 66.57-д заасан шаардлагыг 60 сараас доошгүй хугацаанд хангаж ажилласан байх.</p> <p>2/ өмнөх 24 сарын хугацаанд: 2.1. агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх эзэмшиж <u>техник үйлчилгээний ажил гүйцэтгэж байсан</u>; эсхүл 2.2. агаарын хөлгийн техник үйлчилгээнд хяналт тавьж байсан.</p> <p>3/ агаарын хөлгийн их биед их засвар хийхтэй холбоотой, ИНЕГ-ын даргаас хүлээн зөвшөөрөгдсөн шалгалтыг амжилттай өгсөн байх.</p> <p>4/ <u>ИНД-141</u>-гийн дагуу гэрчилгээжсэн иргэний нисэхийн сургалтын байгууллага, эсхүл ИНЕГ-аас зохион байгуулсан, агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсэгт үзлэг хийхтэй холбоотой сургалтад хамрагдаж бичгийн шалгалтанд хангалттай дүн үзүүлсэн байх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Орхигдуулсан</p>

<p>66.205. Эрх, хязгаарлалт</p> <p>(а) Энэ зүйлийн (b)-г харгалзан, IAC нь тухайн эзэмшигчид дараах эрхийг <u>олгоно</u>:</p> <p>(1) агаарын хөлгийн техник үйлчилгээний жилийн дүгнэлтийг (annual review) ИНД-43-ын D Бүлгийн дагуу хийх;</p> <p>(2) ИНД-43-ын E Бүлгийн дагуу хийгдсэн <u>том хэмжээний засвар</u> болон <u>том хэмжээний модификацийн</u> дараа ИНД-21-ийн Хавсралт D-д заасан техникийн өгөгдөлтэй нийцэж байгааг баталгаажуулах.</p> <p>(b) <u>Тухайн</u> этгээд нь агаарын хөлгийн хүчилсэн бүтэц, хүчний төхөөрөмж, сэнс, эсхүл холбогдох эд анги, эсхүл бүрдэл хэсэгт бүрэн гүйцэд үзлэг шалгалт хийхэд шаардлагатай <u>төхөөрөмж, байгууламж болон тухайн үзлэг шалгалтын өгөгдөл бэлэн</u> байхаас бусад тохиолдолд, энэ зүйлийн (а)-д заасан эрхийг хэрэгжүүлэхгүй.</p>	<p>66.21. Эрх, үүрэг</p> <p>(а) Энэ зүйлийн (б) хэсгийг харгалзан үзсэнээр, агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсэгт үзлэг хийх гэрчилгээ олгогдсон этгээд дараах эрхийг <u>эдэлнэ</u>:</p> <p>1/ ИНД-43-т заасны дагуу агаарын хөлгийн НТЧ-ын жилийн үзлэгийг гүйцэтгэх;</p> <p>2/ ИНД-43-т заасны дагуу <u>үндсэн засварын</u> болон <u>үндсэн өөрчлөлтийн</u> гүйцэтгэл нь ИНД-21-ийн Хавсралтад заасан техникийн өгөгдлүүдтэй нийцэж буйг баталгаажуулах.</p> <p>(б) <u>Үзлэг хийх гэрчилгээ олгогдсон</u> этгээд нь энэ зүйлийн (а) хэсэгт заасан эрхүүдийг агаарын хөлгийн их бие, хөдөлгүүр, сэнс, эд анги, тоног төхөөрөмжүүдийг шалгахад тохирсон техникийн өгөгдлүүдгүй болон <u>ажлын байр, багаж хэрэгсэлгүй тохиолдолд эдлэхгүй</u>.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>66.207. Туршлага хадгалах шаардлага</p> <p>IAC эзэмшигч нь өмнөх 12 сарын хугацаанд дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, тухайн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлэхгүй:</p> <p>(1) 4 удаа агаарын хөлгийн техник үйлчилгээний жилийн дүгнэлтийг ИНД-43-ын D Бүлгийн дагуу хийсэн байх; эсхүл</p> <p>(2) 4 удаа <u>том хэмжээний засвар</u>, эсхүл <u>том хэмжээний модификацийн</u> дараа агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэг нь ИНД-21-ийн Хавсралт D-д заасан өгөгдөлтэй нийцэж байгааг баталгаажуулсан байх; эсхүл</p> <p>(3) <u>энэ зүйлийн (1) болон (2)-т заагдсан ажлын аль алийг нь гүйцэтгэсэн байх; эсхүл</u></p> <p>(4) <u>Даргын</u> хүлээн зөвшөөрөхүйц, 8-аас доошгүй цагийн сэргээх сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх; эсхүл</p> <p>(5) <u>Даргын</u> хүлээн зөвшөөрөхүйц шалгалтыг амжилттай өгсөн байх.</p>	<p>66.207. Дадлага туршлагад тавигдах шаардлага</p> <p>(а) Агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсэгт үзлэг хийх гэрчилгээ олгогдсон этгээд нь өмнөх 12 сарын хугацаанд дараах шаардлагыг хангаагүй тохиолдолд <u>үзлэг хийх гэрчилгээгээр олгогдсон аливаа эрхийг эдлэхгүй</u>:</p> <p>1/ ИНД-43-т заасны дагуу агаарын хөлгийн техник үйлчилгээний жилийн үзлэгийг 4-өөс доошгүй удаа гүйцэтгэсэн байх; эсхүл</p> <p>2/ агаарын хөлөгт, эсхүл түүний бүрэлдэхүүн хэсэгт <u>үндсэн засвар</u> эсхүл <u>үндсэн өөрчлөлт</u> хийгдсэний дараа ИНД-21-ийн Хавсралтад заасан техникийн өгөгдлүүдтэй нийцэж буй эсэхийг 4-өөс доошгүй удаа баталгаажуулсан байх; эсхүл</p> <p>3/ <u>ИНЕГ-аас</u> хүлээн зөвшөөрсөн, 8-аас доошгүй цагийн давтан сургалтанд амжилттай хамрагдсан байх; эсхүл</p> <p>4/ <u>ИНЕГ-аас</u> хүлээн зөвшөөрсөн шалгалтуудад амжилттай дүн үзүүлсэн байх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Орхигдуулсан</p>
<p>Хавсралт А - Шилжилтийн зохицуулалт</p>	<p>ХАВСРАЛТ А Шилжилтийн <u>үеийн</u> зохицуулалт</p>	
<p>(а) ИНД-66-гийн дагуу олгосон үнэмлэх, эсхүл зэрэглэлийг энэ Дүрэм батлагдсанаас хойш 6 сарын дотор шинэчлэн олгоно.</p>	<p>(а) Энэхүү дүрэм батлагдсанаас хойшхи 6 сарын хугацаанд, Дэд бүтцийн сайдын 2001 оны 75 тоот тушаалын хавсралтаар батлагдсан, ИНД-66 “Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтныг үнэмлэх, зэрэглэл” дүрмийн дагуу олгогдсон үнэмлэх, зэрэглэл гэрчилгээнүүдийг шинэчлэн</p>	

<p>(b) Энэ Дүрэм шинэчлэгдэхээс өмнө олгосон AMEL, гэрчилгээ, эсхүл зэрэглэлийг, энэ Дүрмийн дагуу үнэмлэх, гэрчилгээ, эсхүл зэрэглэл шинэчлэн олгох хүртэл хүчинтэйд тооцно.</p> <p><u>(c) Хэрэв Дарга эзэмшигчийн үр чадварыг тогтоох арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл, ИНД-66-гийн дагуу олгосон үнэмлэх, гэрчилгээ, эсхүл зэрэглэл эзэмшигчийг дахин шалгаж болно. Хэрэв шаардлагатай бол Дарга дахин шалгалтын үр дүнд тухайн үнэмлэх, гэрчилгээ, эсхүл зэрэглэлийг өөрчилж, эсхүл цуцалж болно.(шилжилт)</u></p>	<p>олгоно.</p> <p>(б) Энэ дүрэм батлагдахаас өмнө олгогдсон агаарын хөлгийн засвар, техник үйлчилгээний мэргэжлийн аливаа үнэмлэх, гэрчилгээ, зэрэглэлүүдийг, <u>ИНЕГ-аас</u> энэхүү дүрмийн дагуу үнэмлэх, гэрчилгээ, зэрэглэл шинээр олгох хүртэл хүчинтэйд тооцно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>- Part 19-өөс шилжүүлсэн</p>
<p>Хавсралт В - Бүлгийн болон маягийн зэрэглэл</p>	<p>ХАВСРАЛТ Б Бүлгийн болон маягийн зэрэглэл</p>	
<p>В.1. Бүлэг Зэрэглэлийг дараах Бүлгээр олгож болно:</p> <p>(a) Нисэх онгоц: Бүлэг-1: Хүчилсэн металл гадаргуутай, битүүмжлэлгүй, <u>хураагддаггүй хөл ангитай</u>, МСТOW нь 5700 кг-аас хэтрэхгүй жинтэй нисэх онгоц; Бүлэг-2: <u>Хүчилсэн металл гадаргуутай</u>, битүүмжлэлгүй, Бүлэг-1-ээс бусад нисэх онгоц; Бүлэг-3: Үндсэн хийц нь модон эсхүл хөндий хоолой (tubular) бүтэцтэй, даавуун бүрээстэй нисэх онгоц;</p>	<p>Б.1. Бүлгүүд Зэрэглэлийг дараах байдлаар бүлэглэн олгоно:</p> <p>а. Онгоц : бүлэг1: 5700 кг–аас доош <u>хөөрөлтийн жинтэй, их биеийн төмөр хийцтэй</u> битүүмжлэлгүй онгоц бүлэг2: <u>их биеийн төмөр хийцтэй</u> битүүмжлэлгүй, бүлэг 1-д хамрагдахгүй бусад онгоц бүлэг3: <u>хэт хөнгөн онгоц</u></p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p><u>Бүлэг-4: Мяндсаар хүчилсэн пластик (Fibre reinforced plastic), эсхүл төстэй материалаар үндсэн хийц нь хийгдсэн нисэх онгоц;</u></p>	<p><i>2001 онд орхигдуулсан.</i></p>	

<p>(b) Роторт-хөлөг: Бүлэг-1: Поршинт хөдөлгүүртэй <u>роторт- хөлөг</u>; Бүлэг-2: Турбинт хөдөлгүүртэй <u>роторт- хөлөг</u>;</p> <p>(c) Хүчний төхөөрөмж: Бүлэг-1: Агаарын энгийн оролттой (Normally aspirated) поршинт хөдөлгүүр; Бүлэг-2: (Turbocharged, supercharged) <u>эсхүл радиал поршинт хөдөлгүүр</u></p> <p>(d) Цахилгаан: Бүлэг-1: МСТOW нь 5700 кг, эсхүл түүнээс доош жинтэй, <u>битүүмжлэлтэй</u> нисэх онгоц болон <u>дараах цахилгааны анхдагч үүсгүүртэй битүүмжлэлгүй</u> агаарын хөлгийн цахилгаан систем;</p>	<p>б. Нисдэг тэрэг : бүлэг 1: Поршинт хөдөлгүүрт <u>нисдэг тэрэг</u> бүлэг 2: Турбинт хөдөлгүүрт <u>нисдэг тэрэг</u></p> <p>в. Хүчний төхөөрөмж: бүлэг 1: Поршинт хөдөлгүүр бүлэг 2: <u>Турбинт хөдөлгүүр</u></p> <p>г. Цахилгаан: бүлэг1: цахилгааны анхдагч үүсгүүртэй, <u>битүүмжлэлгүй</u>, 5700 кг-аас доош хөөрөлтийн жинтэй онгоцны цахилгаан систем</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>(i) <u>DC генератор; эсхүл</u> (ii) <u>Стартер генератор; эсхүл</u> (iii) <u>өөртөө шулуутгагч агуулсан хувьсах гүйдлийн Алтернатор</u></p>	<p>2001 онд орхигдуулсан.</p>	
<p>Бүлэг 2: Цахилгааны анхдагч үүсгүүр болох дараах цахилгаан систем:</p>	<p>бүлэг 2: тогтмол эргэлтийн төхөөрөмжөөс цахилгааны анхдагч үүсгүүрүүд нь тэжээгддэг цахилгаан систем</p>	<p>Орчуулга зассан</p>
<p>(i) <u>DC генератор, эсхүл стартер генератор болон хоёрдогч эх үүсвэр болдог тогтмол бус давтамжтай хувьсах гүйдлийн генератор; эсхүл</u> (ii) <u>тогтмол эргэлтийн төхөөрөмжөөс эргэлтээ авдаг тогтмол давтамжтай AC алтернатор;</u></p>	<p>2001 онд орхигдуулсан.</p>	
<p>(e) Хэрэглэл: Бүлэг-1: агаарын хөлгийн хэрэглэлийн ерөнхий систем; нислэгийн хэрэглэлийн үндсэн систем; МСТOW нь 5700 кг, эсхүл түүнээс дээш <u>жинтэй</u>, битүүмжлэлтэй нисэх онгоцонд суурилагдсанаас бусад, хүчилтөрөгчийн систем, <u>бүхээгийн даралтын</u> болон агааржуулалтын систем; Бүлэг-2: МСТOW нь 5700 кг, эсхүл түүнээс дээш жинтэй битүүмжлэлтэй нисэх онгоцонд <u>суурилагдсанаас бусад</u>, <i>air data computer</i> системийг багтаасан <i>auto flight</i> болон навигацийн систем, <i>servo driven</i> хэрэглэл, <i>remote reading compasses</i>-ийг багтаасан <i>remote gyro</i> систем, <i>automatic flight control</i> систем болон <i>inertial navigation</i> систем;</p>	<p>д. Хэрэглэл : бүлэг1: агаарын хөлгийн хэрэглэлийн ерөнхий систем; нислэгийн хэрэглэлийн үндсэн систем; 5700-аас дээш хөөрөлтийн жинтэй битүүмжлэлтэй онгоцонд суурилагдсанаас бусад битүүмжлэлийн болон агааржуулалтын систем, хүчилтөрөгчийн систем; бүлэг 2: 5700-аас дээш хөөрөлтийн жинтэй битүүмжлэлтэй онгоцонд суурилагдсан, автомат нислэгийн удирдлагын системүүд болон навигацийн систем:</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>(f) Радио холбоо: Бүлэг-1: VHF, HF, CVR, аудио систем болон ELT-г <u>багтаасан нислэгийн холбооны</u> систем;</p>	<p>е. Радио холбоо : бүлэг 1: VHF, HF, CVR, зорчигчид мэдээлэл өгөх холбооны систем болон ELT –ыг <u>хамарсан, агаарын хөлгийн холбооны</u> системүүд:</p>	<p>-Найруулга зассан</p>

<p>Бүлэг-2: ADF, VOR, ILS, VLF, Omega, маркерын дохио, GPS болон GNSS–г багтаасан нислэгийн навигацийн систем;</p> <p>Бүлэг-3: Цаг агаарын радар, doppler, радио өндөр-хэмжигч, DME, транспондер, ADS-B систем болон TCAS-ийг багтаасан ажиглалтын систем;</p>	<p>бүлэг 2: ADF, VOR, ILS, VLF, Omega, маркерийн радио дамжуулагч (marker beacon), GPS болон GNSS хамарсан, агаарын хөлгийн навигацийн системүүд:</p> <p>бүлэг 3: цаг агаарын радар, Доплирын хэрэглэл (doppler), радио өндрийн хэмжүүр, DME, автомат хариулагч, болон TCAS хамарсан, агаарын хөлгийн анхдагч болон хоёрдагч радиолокатор:</p>	
<p>(г) Агаараас хөнгөн агаарын хөлөг</p> <p>Бүлэг-1: Халуун агаарын чөлөөт бөмбөлөг болон халуун агаарын дирижабль бүхэлдээ;</p> <p>Бүлэг-2: Хөнгөн хийгээр дүүргэсэн дирижабль болон түүний бүрдэл хэсэг; хөдөлгүүр болон сэнс, эсхүл fan, эсхүл аль аль нь багтахгүй.</p>	<p>ж. Агаараас хөнгөн агаарын хөлөг.</p> <p style="text-align: center;"><i>2001 онд орхигдуулсан.</i></p>	
<p>В.2. Маяг</p> <p>Дарга, дараах агаарын хөлгийн, эсхүл бүрдэл хэсгийн маяг тус бүрээр агаарын хөлгийн, эсхүл бүрдэл хэсгийн маягийн зэрэглэл олгох үүрэгтэй.</p> <p>(1) Нисэх онгоц: битүүмжлэлтэй нисэх онгоц;</p> <p>(2) Роторт-хөлөг: роторт- хөлгийн Бүлэг-1, эсхүл Бүлэг-2 зэрэглэлд хамаарахгүй гэж Даргын үзсэн роторт- хөлөг;</p> <p>(3) <u>Хүчний төхөөрөмж</u>: турбинт хүчний төхөөрөмж;</p> <p>(4) Цахилгаан: МСТOW нь 5700 кг-аас дээш <u>жинтэй</u>, битүүмжлэлтэй нисэх онгоцонд суурилуулсан цахилгааны систем болон төхөөрөмж;</p> <p>(5) Хэрэглэл: МСТOW нь 5700 кг-аас дээш <u>жинтэй</u>, битүүмжлэлтэй нисэх онгоцонд суурилуулсан нислэгийн нэгдсэн систем (integrated flight system) ;</p> <p>(6) Радио холбоо: МСТOW нь 5700 кг-аас дээш жинтэй, битүүмжлэлтэй нисэх онгоцонд суурилуулсан радио холбооны бүрэн тоноглол;</p> <p>(7) Бүрдэл хэсэг: ИНД-43.54 (b), (c)-д заагдсан агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн их засвар болон техник үйлчилгээ.</p>	<p>Б.2. Маягууд</p> <p>Зэрэглэлүүдийг тодорхой агаарын хөлөг, эсхүл бүрэлдэхүүн хэсгийн хувьд маягийн зэрэглэл гэж ИНЕГ-ын даргаас олгоно.</p> <p>а. Онгоц: битүүмжлэлтэй онгоцнууд;</p> <p>б. Нисдэг тэрэг: Нисдэг тэрэгний Бүлэг 1 болон Бүлэг 2 зэрэглэлд хамаарахгүй гэж ИНЕГ-ын даргаас үзсэн нисдэг тэрэгнүүд</p> <p>в. <u>Хөдөлгүүр</u>: турбинт хүчний төхөөрөмжүүд</p> <p>г.Цахилгаан: 5700 кг-аас дээш <u>хөөрөлтийн жинтэй</u> битүүмжлэлтэй онгоцонд суурилуулсан тоноглолууд болон цахилгааны систем:</p> <p>д. Хэрэглэл: 5700 кг-аас дээш хөөрөлтийн жинтэй битүүмжлэлтэй онгоцонд суурилуулсан нислэгийн нэгдсэн систем:</p> <p>е.Радио холбоо: 5700 кг-аас дээш <u>хөөрөлтийн жинтэй</u> битүүмжлэлтэй онгоцонд суурилуулсан радио холбооны бүрэн тоноглолууд:</p> <p>ж. Бүрэлдэхүүн хэсэг: ИНД-43 -д тусгагдсан, агаарын хөлгийн, эсхүл түүний бүрэлдэхүүн хэсгийн техник үйлчилгээ болон их засвар</p>	<p>-Найруулга зассан, дутуу гүйцээсэн</p>
<p>Хавсралт С - Нэмэлт эрх</p> <p>(a) Нисэх онгоцны категори, эсхүл роторт- хөлгийн категориин үнэмлэх эзэмшигч нь, хэрэв холбогдох агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй бол, дараах техник үйлчилгээг гүйцэтгэх, эсхүл хяналт тавих болон ашиглалтад</p>	<p>ХАВСРАЛТ В – Нэмэлт эрх</p> <p>(a) Онгоц эсхүл нисдэг тэрэгний ангиллын хувьд, үнэмлэх эзэмшигч нь тодорхой маягийн агаарын хөлөг дээр зэрэглэлтэй бол дараах техник үйлчилгээг хийх, эсхүл хяналт тавих болон уг техник үйлчилгээнээс гаргах нэмэлт эрхийг эдэлнэ:</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>шилжүүлэхээр гэрчилгээжүүлж болно:</p> <p>(1) Бүлэг-1-ийн зэрэглэлд багтах цахилгааны болон хэрэглэлийн систем болон Бүлэг-1, 2 болон 3-ын зэрэглэлд багтах радио системд ИНД-91-ийн G Бүлэг, эсхүл ИНД-125-ын G Бүлэг, эсхүл ИНД-135-ын G Бүлэгт шаардсан холбогдох үзлэг шалгалт;</p> <p>(2) тусгай тестийн төхөөрөмж шаардлагатайгаас бусад тохиолдолд, тухайн агаарын хөлөг дээр хийгдэх цахилгааны ба хэрэглэлийн бүрдэл хэсэг, системийн (компасын систем багтахгүй) солилт, тохируулга болон ажиллагааны тест;</p> <p>(3) цахилгаан цэнэг хуримтлуулагчийн (battery) техник үйлчилгээ;</p> <p>(4) VHF, HF радио системийг суурилуулах болон техник үйлчилгээ;</p> <p>(5) шугамын үйлчилгээний үед сольж болох эд ангийг солих;</p> <p>(6) компас системд, шууд ба зайн уншилтын компасын (direct and remote reading compasses) тэнцүүлэх тохируулга хийх, шууд уншилтын компасын системийн бүрдэл хэсгийг солихоор хязгаарлах.</p>	<p>1/ Бүлэг 1-ийн цахилгааны болон хэрэглэлийн системүүдэд, Бүлэг 1, 2 ба 3-ийн радио холбооны системүүдэд ИНД-91, ИНД-135-д заасаны дагуу хийгдэх үзлэг шалгалтууд;</p> <p>2/ тухайн агаарын хөлөг дээр тусгай зориулалтын шалгах тоног төхөөрөмж шаардагдахгүй цахилгааны ба хэрэглэлийн эд анги, системүүд (энд компасын систем хамаарахгүй)-ийн ажиллагааг шалгах, тохируулах, солих үйлчилгээ;</p> <p>3/ цахилгаан цэнэг хуримтлуулагчид хийх техник үйлчилгээ;</p> <p>4/ VHF, HF радио системийг суурилуулах, түүнд хийх техник үйлчилгээ;</p> <p>5/ шугмын үйлчилгээний үед сольж болох эд ангийг солих;</p> <p>6/ шууд ба зайн уншилтын компасын тэнцүүлэх хязгаарыг хийх ба шууд уншилтын компасын эд ангийг солих.</p>	
<p>(b) Хүчний төхөөрөмжийн категориин үнэмлэх эзэмшигч нь, хэрэв холбогдох хүчний төхөөрөмжийн маягийн зэрэглэлтэй бол, дараах техник үйлчилгээг хийх, эсхүл хяналт тавих болон ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлж болно:</p> <p>(1) тусгай тестийн төхөөрөмж шаарддаггүй бол, хөдөлгүүрийн хэрэглэлийн ажиллагааг шалгах болон тест;</p> <p>(2) тусгай тестийн төхөөрөмж шаарддаггүй бол, хөдөлгүүрт хамаарах бүрдэл хэсэг, системийн солилт, тохируулга болон ажиллагааны тест;</p> <p>(3) шугамын техник үйлчилгээний үед сольж болох, хүчний төхөөрөмжид хамаарах авионикийн эд ангийг солих.</p>	<p>(б) Хүчний төхөөрөмж/хөдөлгүүрийн ангиллын хувьд, үнэмлэх эзэмшигч нь тодорхой маягийн хөдөлгүүрийн зэрэглэлтэй бол дараах нэмэлт техник үйлчилгээг хийх, эсхүл хяналт тавих болон техник үйлчилгээнээс гаргах эрхтэй:</p> <p>1/ тусгай зориулалтын шалгах тоног төхөөрөмж шаардагдахгүй, хөдөлгүүрийн хэрэглэлүүдийн ажиллагааг шалгах;</p> <p>2/ тусгай зориулалтын шалгах тоног төхөөрөмж шаардагдахгүй, хөдөлгүүрт хамаарах эд ангиуд, системүүдийн ажиллагааг шалгах, тохируулах, солих;</p> <p>3/ шугамын үйлчилгээний үед сольж болох авионик эд ангийг солих.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>(c) Цахилгаан, хэрэглэл, эсхүл радио холбооны категориин зэрэглэлтэй үнэмлэх эзэмшигч нь дараах техник үйлчилгээ хийх, эсхүл хяналт тавих болон ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлж болно:</p> <p>(1) Бүлэг-1-ийн зэрэглэлийн цахилгааны болон хэрэглэлийн систем болон Бүлэг-1, 2 болон 3-ын зэрэглэлийн радио холбооны системд ИНД-91-ийн G Бүлэг, ИНД-125-ын G Бүлэг, ИНД-135-ын G Бүлэгт шаардсан холбогдох үзлэг</p>	<p>(в) Цахилгаан, хэрэглэл, эсхүл радио холбооны ангиллын хувьд зэрэглэлтэй үнэмлэх эзэмшигч нь дараах техник үйлчилгээг хийх, эсхүл хяналт тавих болон уг техник үйлчилгээнээс гаргах нэмэлт эрхийг эдэлнэ:</p> <p>1/ Бүлэг 1-ийн цахилгааны болон хэрэглэлийн системүүдэд, Бүлэг 1, 2 ба 3- радио холбооны системүүдэд ИНД-91, ИНД-135-д заасаны дагуу хийгдэх үзлэг шалгалтууд;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>шалгалт;</p> <p>(2) тусгай <u>тестийн</u> төхөөрөмж шаардлагатайгаас бусад тохиолдолд, тухайн агаарын хөлөг дээр хийгдэх цахилгааны болон хэрэглэлийн бүрдэл хэсэг, системийн (компасын систем багтахгүй) солилт, <u>тохируулга болон ажиллагааны тест</u>;</p> <p>(3) цахилгаан цэнэг хуримтлуулагчийн (battery) техник үйлчилгээ;</p> <p>(4) VHF, HF радио системийг суурилуулах, түүнд хийх техник үйлчилгээ;</p> <p>(5) шугамын <u>техник</u> үйлчилгээний үед сольж болох эд ангийг солих;</p>	<p>2/ тухайн агаарын хөлөг дээр <u>тусгай зориулалтын шалгах</u> тоног төхөөрөмж шаардагдахгүй цахилгааны ба хэрэглэлийн эд анги, системүүд (энд компасын систем хамаарахгүй)-ийн ажиллагааг шалгах, тохируулах, солих үйлчилгээ;</p> <p>3/ цахилгаан цэнэг хуримтлуулагчид хийх техник үйлчилгээ;</p> <p>4/ VHF, HF радио системийг суурилуулах, түүнд хийх техник үйлчилгээ;</p> <p>5/ шугамын үйлчилгээний үед сольж болох эд ангийг солих;</p>	
<p>(d) Агаараас хөнгөн агаарын хөлгийн <u>категорийн</u> зэрэглэлтэй үнэмлэх эзэмшигч нь дараах техник үйлчилгээг хийх, эсхүл хяналт тавих болон <u>ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлж</u> болно:</p> <p>(1) ИНД-91-ийн <u>G Бүлэг, ИНД-125-ын G Бүлэг, ИНД-135-ын G Бүлэг</u> шаардсан байнгын үзлэг;</p> <p>(2) тусгай <u>тестийн</u> төхөөрөмж шаардлагатайгаас бусад тохиолдолд, тухайн агаарын хөлөг дээр хийгдэх цахилгааны болон хэрэглэлийн <u>бүрдэл хэсэг</u>, системийн (компасын систем багтахгүй) солилт, тохируулга болон ажиллагааны тест;</p> <p>(3) хэрэглэлийн холболт, цахилгааны утсыг засах, солих;</p> <p>(4) VHF, HF радио системийг суурилуулах;</p> <p>(5) шууд уншигдах компасын тэнцүүлэх тохируулга хийх, бүрдэл хэсгийг солих.</p>	<p>(г) Агаараас хөнгөн агаарын хөлгийн <u>ангиллын</u> хувьд зэрэглэлтэй үнэмлэх эзэмшигч нь дараах техник үйлчилгээг хийх, эсхүл хяналт тавих болон уг <u>техник үйлчилгээнээс гаргах нэмэлт эрхийг эдэлнэ</u>:</p> <p>1/ ИНД-91, ИНД-135-д заасаны дагуу хийгдэх тогтмол үзлэг шалгалтууд;</p> <p>2/ тухайн агаарын хөлөг дээр <u>тусгай зориулалтын</u> шалгах тоног төхөөрөмж шаардагдахгүй цахилгааны ба хэрэглэлийн <u>эд анги</u>, системүүд (энд компасын систем хамаарахгүй)-ийн ажиллагааг шалгах, тохируулах, солих үйлчилгээ;</p> <p>3/ салгаж болох цахилгааны холбоос, зангилаа эд ангийг засах солих;</p> <p>4/ VHF, HF радио системийг суурилуулах, түүнд хийх техник үйлчилгээ;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

Дүрмийн боловсруулалтын хэлтэс